



## Сайн Найзууд

**ЭВ НЭГДЭЛ** Бид бие биенээ хүндэлдэг.

### Унших Зүйл

1 Самуел 18:1-5, 20:1-42; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 649-655.

### Цээжлэх Ишлэл

"Ионатан Давидыг өөрийн адил хайрлажээ" (1 Самуел 18:3).

### Зорилго

#### Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Их Эзэн өөрсдийг нь найз нартаа үнэнч шударга байгаасай гэж хүсдэгийг мэдэх болно.

Найзуудтай байгаадаа баярлах болно.

Найз нартаа үнэнч шударга байж хариу үзүүлэх болно.

### Гол Санаа



Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.

## Хичээлд Бэлтгэх нь

### Библийн Хичээлийн Товчлол

Давид Ионатан хоёр сайн найзууд. Ионатан Саул хааны хүү байжээ. Саул хаан Давидад атаархаж түүнийг хороохыг завдахад Ионатан Давидад тусалдаг байжээ. Тэд амьдралынхаа туршид үргэлж сайн найзууд байх болно хэмээн бие биедээ амлажээ.

### Энэ бол эв нэгдлийн тухай хичээл

Жинхэнэ найзууд бие биедээ анхаарал халамж тавьдаг. Жинхэнэ найзууд хэзээд үнэнч шударга байж чаддаг.

### Багшийн Баяжуулалт

"Голиатыг гайхалтайгаар ялсны дараа, Саул хаан Давидыг гэртээ буцахыг нь болиулан өөрийн хажуудаа авсан нь Их Эзэнээс үг авдаг хэн нэгэнтэй хамт байвал өөрийнх нь хаанчлал тайван аюулгүй байх болно гэж бодсон учраас юм. Их Эзэн Давидыг өөрийн хамгаалал болон ивээлдээ авснаас хойш, Саул хаан өөрийн хамгаалалт болгон Давидтай хамт дайнд явдаг байжээ.

"Давидыг Саултай нэгдүүлсэн явдал нь Их Эзэний урьдаас бэлдсэн төлөвлөгөө байсан юм. Давид Саулын

# ХОЁР

<b>Хичээлийн Төлөвлөгөө</b>				
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ	
<b>Мэндчилгээ</b>	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух		
<b>1</b>	<b>Бэлтгэх Ажил</b>	10 минут	<i>А. Нүүр Тулах</i> <i>Б. Найзын Тэврэлт</i> <i>В. Эрхий Хурууны Найз</i>	байхгүй байхгүй байхгүй
<b>*</b>	<b>Залбирал ба Магтаал*</b>	10 минут	27-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал-ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
<b>2</b>	<b>Библийн Хичээл</b>	20 минут	Түүхтэй Танилцах Библи Судлал Цээжлэх Ишлэл	байхгүй Библи Библи
<b>3</b>	<b>Хичээлээ Заах</b>	15 минут	<i>Найзууд</i>	<i>Бяцхан Хүүхдүүд Түүнийг</i> <i>Магтана Дууны ном</i>
<b>4</b>	<b>Хичээлээ Хуваалцах нь</b>	15 минут	<i>Сумаа Хуваалцах нь</i>	сумны загвар (140-р хуудас), хатуу цаас, өнгийн харандаа, хайч

хамт байх нь түүнд ашигтай байсан бөгөөд ирээдүйд хүлээж буй том үйлсэд нь бэлтгэл болж, Давид ч тэнд олон зүйл сурч байсан юм. Мөн энэ нь ард түмний итгэлийг өөртөө хүлээх том боломж байсан. Саулын хорсол дайсагналаар ирсэн зовлон зүдгүүр нь Давидыг Их Эзэнтэй улам хамааралтай гэдгийг нь болон Их Эзэнд бүрэн итгэж найдахад түүнийг хүргэсэн юм. Давид Ионатан хоёрыг найзууд болгосон нь ч Их Эзэний төлөвлөгөө байсан ба энэ нь Израйлийн ирээдүйн удирдагчийг хамгаалах нэгэн

арга байжээ. Энэ бүх зүйлээр дамжуулан Их Эзэн өөрийн хүмүүс болох Израйльчууд болон Давидад зориулсан төлөвлөгөөгөө хэрэгжүүлсэн юм. (*Эцэг Өвгөд ба Зөнчид*, х. 649)

## **Өрөөний Зохион Байгуулалт**

Нэгдүгээр хичээлээс үлдсэн тайзны засал дээр нэмээд ягаан болон улаан өнгийн даавуугаар бүтээсэн түшлэгтэй сандлыг ашиглан хааны өрөөг засаарай. Мөн энэ заслаа 3-8, 12, 13-р хичээл дээр хэрэглээрэй.

## Заах Хичээл

### Мэндчилгээ

Үүдэнд сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

### Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

#### А. Мужааны Газар

Хүүхдүүдийг хос хосоор нь зогсоогоод асуух нь: Хүн бүр өөрийн гэсэн хамтрагчтай байх ёстой. Одоо хамтрагчийнхаа нүүр лүү хараад хэн нь эхний удирдагч болохоо шийд. Намайг "Эхэл" гэж хэлэхэд удирдагч болсон хүүхэд нь нүүрээ инээдтэйгээр хувиргах ёстой. Харин нөгөөх нь инээж эсвэл дооглож болохгүй. "Эхэл". Хүүхдүүд хийж дуусах хүртэл хугацаа өгөөрэй.

Одоо та нар солигдох ёстой. Удирдагч болоогүй хүүхэд энэ удаа удирдагч болоод намайг "Эхэл" гэж хэлэхэд инээдтэй царай гаргах хэрэгтэй. Үүнийг хийхэд хүүхдүүдэд хугацаа өгөөрэй. Одоо харин намайг дахиад "Эхэл" гэж хэлэхэд эхний удирдагч болсон хүүхэд нүүрээ инээдтэйгээр хувиргаж хамтрагч түүнийг дуурайх ёстой. "Эхэл". Хүүхдүүд бие биенээ дуурайж дуустал хугацаа олгоорой. Одоо удирдагч нар солигдох хэрэгтэй. Намайг "Эхэл" гэж хэлэхэд та нар нүүрээ инээдтэйгээр хувиргаарай. Харин хамтрагч чинь чамайг дуурайх болно.

#### Багатгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Хамтрагч чинь нүүрээ инээдтэй болгож байхад та нарыг би инээж шоолж болохгүй гэж хэлэхэд ямар байсан бэ? Хамтрагчийнхаа царайг дуурайх тухай та нар юу гэж бодож байна вэ? Аль нь амархан байсан бэ? Инээхгүй байх нь амархан байсан уу? Дуурайх нь амархан байсан уу? Яагаад тэгж бодож байна вэ? Чи найз шигээ байхыг хүсээд түүний юу хийснийг нь дуурайсан гэж үү?**

**Жинхэнэ найзууд бие биедээ хайртай байдаг. Нэг нь гунигтай байхад нөгөөх нь ч мөн гуниж байдаг. Нэгд нь тусламж хэрэгтэй болвол нөгөөх нь түүнд туслахыг хичээж байдаг. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх хоёр найзын тухай түүх юм. Тэд хамтдаа байх дуртай, бие биедээ тусалдаг, бас бие биедээ хайртай байжээ. Есүс биднийг яг ийм л байхыг хүсдэг. Өнөөдрийн бидний хичээлийн гол утга санаа бол:**



**Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.**

**Намайг дагаад хэлээрэй.**

## Б. Найзын Тэврэлт

Хүүхдүүдийг тойруулан суулгаад (олон хүүхэдтэй ангид бол хэд хэдэн тойрог үүсгэх хэрэгтэй) нэг хүүхэд тойргоор явж ангийнхаа хүүхдүүдийн толгой эсвэл мөрөн дээр нь аяархан цохиод "Найз, найз, найз" гэнэ. Тухайн хүүхэд нэг хүүхэд сонгох үед бусад нь "Тэврээрэй" гэж хэлнэ. Сонгогдсон хүүхэд босоод тойрог дундуур өөрийг нь сонгосон хүүхдийг хөөж тоглох ба эхний хүүхэд баригдвал сонгогдсон хүүхэд түүнийг тэврэх ёстой. Хэрвээ эхний хүүхэд хоосон зайд түрүүлээд орчихвол сонгогдсон хүүхэд тойргоор явж найзаа сонгоно. Хүүхэд бүр найзаа сонгох тоглоом тоглож дуусах хүртэл үргэлжлүүлээрэй.

### Бататгах нь

Хэлэх: Хэн нэгнийг тэврэх гээд хөөхөд та нарт ямар байсан бэ? Чи дандаа ингэмээр байна уу? Мэдээж үгүй шүү дээ. Найзууд бие биедээ хайртай байдаг бөгөөд хайртай гэдгээ ч үзүүлж чаддаг. Нэг нь уйтгарлаж байхад нөгөө нь ч гэсэн найзынхаа төлөө гунигтай байдаг. Нэгэнд нь тусламж хэрэгтэй байвал нөгөө нь туслахыг хичээдэг. Хэн нэгэнд нь урам зориг хэрэгтэй байхад нөгөө нь түүнийг тэвэрдэг билээ. Өнөөдрийн бидний үзэх түүх бол онцгой хоёр найзын тухай юм. Тэд бие биедээ санаа тавьж, хамтдаа хөгжилдөж, бие биенээ хайрлаж байсан. Есүс өнөөдөр биднийг найз нартаа ингэж л хандахыг хүсэж байдаг.



Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.

Намайг дагаад хэлээрэй.

## В. Эрхий Хурууны Найз

Ангийн дөрвөн буланд хүүхдүүдийг бүлэг бүлэг болгон суулгаад бүлэг болгон тойрон нөгөө бүлгүүдээрээ явж хүүхдүүд хоорондоо эрхий хуруугаа нийлүүлээд "Надад нэг найз бий, тэр нь чи" гэж хэлнэ.

### Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: Бид ангиа тойроод найзууддаа тэднийг онцгой болохыг хэлэхээр явлаа. Та нар найз нартайгаа юу хийх дуртай вэ? Та нарт үргэлж хамт байхыг хүсдэг нэгэн дотны найз бий юу? Өнөөдрийн бидний Библийн түүх бол маш сайн найзууд байсан хоёр хүүгийн тухай юм. Тэд бие биедээ санаа тавьж, хамтдаа нөхөрлөж, мөн бие биедээ хайртай байжээ. Өнөөдөр Есүс биднийг яг ийм л байгаасай гэж хүсдэг. Өнөөдрийн хичээлийн гол санаа бол:



Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.

Намайг дагаад хэлээрэй.

(Adapted from Lively Bible Lessons for Preschoolers [Loveland, Colo.: Group Publishing, Inc., 1991], p. 26.)

2

**Библийн Хичээл**

**Түүхтэй Танилцах**

Хэлэх: **Өнөөдөр бид нэгэн хаан ба хоёр сайн найзын тухай ярилцах болно. Давид болон Ионатан нар маш сайн найзууд байжээ. Харин тэр үед Саул хаан байв.**

<b>Та:</b>	<b>Хүүхдүүд:</b>
<b>Саул хаан</b>	муухай хараад гараа ташаан дээрээ тавих
<b>Давид</b>	инээмсэглэх
<b>Ионатан</b>	нум сум харвах гэж байгаа мэт зогсох
<b>Найз, найзууд</b>	зүрхэн дээрээ гараа тавих

**Түүхийг уншиж, эсвэл ярьж өгөөрэй.**

**Саул хаан** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] **Давидыг** [инээмсэглэх] авчруулаад "**Давид** [инээмсэглэх], чи энд үлдэж ордонд амьдрахыг хүсээ юу" гэв.

Тэгээд Давид [инээмсэглэх] **Саул хааны** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] ордонд нүүн ирж **Саул хааны** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] хий гэсэн бүхнийг хийж байлаа. Тэр **Саул хааны** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] хэлсэн бүхнийг сайн биелүүлж байсан учраас түүнийг цэргийн ахлагч болгожээ.

**Давид** [инээмсэглэх] **Саул хааны** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] том хүү **Ионатантай** [нум сум харвах] нөхөрлөн сайн **найзууд** [гараа зүрхэн дээрээ тавих] болцгоосон ба тэд үргэлж хамт байх дуртай байлаа.

"Хамтдаа явж нум харвацгаая" гэж **Ионатан** [нум сум харвах] найздаа [гараа зүрхэн дээрээ тавих] хэлэхэд "Тэгвэл бас хамтдаа явж ой дундуур морь унацгаая" гэж **Давид** [инээмсэглэх] найздаа [гараа зүрхэн дээрээ тавих] хэллээ. **Ионатан** [нум сум харвах] **Давидад** [инээмсэглэх] өмсөж байсан хувцсаа хүртэл өгч түүнийг яг л өөрийн адил хайрладаг

байжээ. **Давид** [инээмсэглэх] ч мөн **Ионатанд** [нум сум харвах] маш их хайртай байв.

Израилийн ард түмэн **Давидад** [инээмсэглэх] хайртай байсан бөгөөд энэ нь **Саул хааныг** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] ихэд хилэгнүүлжээ. Ард түмэн өөрөөс нь илүү **Давидад** [инээмсэглэх] сайн байгааг хараад **Саул хаан** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] **Давидыг** [инээмсэглэх] хороохоор шийдсэнийг **Давид** [инээмсэглэх] мэдээд "Танай аав, **Саул хаан** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] намайг алах гэж байна" хэмээн **Ионатанд** [нум сум харвах] хэлэхэд **Ионатан** [нум сум харвах] "Ийм юм байх ёсгүй" гэв.

"Үгүй ээ, энэ үнэн. Би үүнийг батлах болно. Оройн зоог дээр намайг байхгүй байгааг аав тань мэдээд асуувал намайг гэрлүүгээ явсан гэж хэлээрэй. Хэрвээ танай аав үүнийг сонсоод ихэд харамссан харагдвал намайг алах гэж байгаа биш гэж үү" гэж **Давид** [инээмсэглэх] хэлэхэд **Ионатан** [нум сум харвах] "За, чи тэгвэл чулуун хаднуудын ард нуугдаж бай. Үнэхээр манай аав чамайг алах гэж байвал би чамд хэлэх болно. Тэгээд чи зугтаж амжина" гэлээ.

"Энэ миний төлөвлөгөө байна. Би чулуун хадны зүг гурван удаа нум харваад үйлчлэгч хөвгүүнийг сумаа авахуулахаар явуулъя. Хэрвээ би түүнд "Сум бүр цаана чинь байна. Ахиад цаашаа яв" гэж хэлвэл чи зугтаагаарай. Тэр үед чи үнэхээр миний аав чамайг алах гэж байгаа эсэхийг мэдэх болно" гэж **Ионатан** [нум сум харвах] хэлжээ.

Орой болоход **Саул хаан** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] зоогийн ширээн дээр суугаад **Давидыг** [инээмсэглэх] байхгүй байгааг мэдсэн ч юу ч хэлсэнгүй. Дараагийн орой

**Давид** [инээмсэглэх] бас л байхгүй байгааг хараад **Саул хаан** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] **Ионатанаас** [нум сум харвах] **Давидын** [инээмсэглэх] хаана байгааг асуухад **Ионатан** [нум сум харвах] **Давидыг** [инээмсэглэх] гэртээ харьсан гэж хэлэв.

Гэтэл **Саул хаан** [муухай хараад гараа ташаан дээрээ тавина] маш их уурлан "**Давидыг** [инээмсэглэх] хаан болоосой гэж чамайг хүсэж байгааг чинь би мэдэхгүй гэж бодож байна уу, чи?, **Давидыг** [инээмсэглэх] авчир, би түүнийг алах болно" гэжээ.

Аавыгаа муу зүйл хийж байгаад **Ионатан** [нум сум харвах] ихэд харамсаж байсан ч тэр аавдаа хайртай, бас найзыгаа [гараа зүрхэн дээрээ тавих] зовоохыг хүсэхгүй байлаа.

Дараагийн өглөө нь **Ионатан** [нум сум харвах] чулуун хадны зүг нум харваж үйлчлэгч хүүг сум авахуулахаар явуулаад "Бүүр хол яв. Хурдлаарай" гэж хашхирав.

Тэгээд **Ионатан** [нум сум харвах] үйлчлэгч хүүг хот руу явуулаад **Давидтай** [инээмсэглэх] салах ёс хийн тэврээд үйлжээ. **Найзыгаа** [гараа зүрхэн дээрээ тавих] явах гэж байгаад **Ионатан** [нум сум харвах] ихэд гунигтай байсан бөгөөд **Давид** [инээмсэглэх] ч мөн **Ионатантай** [нум сум харвах] ахин уулзаж чадахгүй болов уу хэмээн санаа зовж байлаа.

"Бид хэсэг хугацаанд уулзаж чадахгүй байх. Хэдий тийм ч бид үргэлж найзууд [гараа зүрхэн дээрээ тавих] байх болно" гэж **Ионатан** [нум сум харвах] хэлэхэд "Тиймээ, бид үргэлж **найзууд** [гараа зүрхэн дээрээ тавих] байх болно" гэж **Давид** [инээмсэглэх] хэлэв.

### **Бататгах нь**

Асуух: **Давид** хаана амьдардаг байсан бэ? **Саул** хаан яагаад **Давидад** уурласан бэ? **Давидын** хувьд **Ионатан** жинхэнэ найз нь байсан уу? **Ионатан** **Давидад** хэрхэн тусалсан бэ? Түүхийн төгсгөлд **Давид** **Ионатан** хоёр яагаад их гунигтай байдаг вэ? Чамд сайн найз бий юу? Чи сайн найзтайгаа ихэвчлэн юу хийдэг вэ? Чи найддаа хайртай гэдгээ харуулж чадах ямар зүйл хийдэг вэ? **Санагтун:**



Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.

Намайг дагаад хэлээрэй.

### **Библи Судлал**

Библиэ нээгээд 1 Самуел 18:1-5 болон 20:1-42-г гаргаад "**Өнөөдрийн бидний үзэх түүх Библийн маань энэ хэсэгт байна**" гээд ишлэлүүдийг чангаар уншаарай.

**Хэрэгтэй зүйлс:**

Библи

### **Бататгах нь**

Асуух: **Хэн хэн** найзууд байсан бэ? **Сайн** найзаа гэж батлахын тулд **Ионатан** **Давидад** юу хийсэн бэ? **Ионатан** **Давидад** хэр зэрэг хайртай байсан бэ? (яг л өөр шигээ). **Ионатан** **Давидад** хэрхэн тусалсан бэ? Тэр яг л жинхэнэ найз шиг байсан уу?

Чи яаж жинхэнэ найз байж чадах вэ? **Санагтун:**



Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.

Намайг дагаад хэлээрэй.

**Хэрэгтэй зүйлс:**

□ Библи

**Цээжлэх Ишлэл**

Библиэ нээгээд 1 Самуел 18:3-г гаргаад **"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна"** гэж хэлээрэй. **"Ионатан Давидад яг л өөр шигээ хайртай байсан"** гэсэн ишлэлийг чангаар уншаад дараах хөдөлгөөнийг хамт хийлгээрэй.



**Ионатан** Өөрийгөө заах.



**Давидыг** Бусдыг заах.



**өөрийн адил** Өөрийгөө заах.



**хайрлажээ.** Гараа цээжин дээр зөрүүлээд тавих.



**1 Самуел 18:3** Алгаа ном мэт дэлгэнэ.

**3**

**Хичээлээ Заах**

**Найзууд**

Хүүхдүүд найзууддаа хэрхэн ханддаг талаар уншиж өгөх гэж байгаагаа хэлээрэй. Тэгээд таны уншсан зүйлээс найзтайгаа сайнаар хандах талаар гарвал эрхий хуруугаа гозойлгох ба хэрвээ эсрэгээрээ байвал эрхий хуруугаа доош нь харуулаарай. Доорх зүйлийг уншина уу.

1. Батын найз анх удаа дугуй унаж сурахаар явахдаа туслах дугуйгүйгээр унаж байгааг хараад Бат найздаа "Чи үнэхээр сайн зүйл хийж байна" гэж хэлэв.
2. Сараа Зулаатай уралдаж байгаад уначив. Харин Зулаа зогсож түүнд тусалжээ.
3. Анука Номингийн хүүхэлдэйг авахыг хүсэж байсан ч чадахгүй гэдгээ мэдэж байлаа. Тэгээд Анука Номингийн хүүхэлдэйнх нь хөлөн дээр үзгээр зурж эхлэв.
4. Анхаагийн ээж хүүдээ нэг аяга жимс өгөхөд Анхаа ээжээсээ энэ аягатай жимсээ Итгэлтэй хуваалцаж болох уу хэмээн асуужээ.
5. Хүүхдүүд нуугдаж тогложээ. Гэтэл Баяраа хэнийг ч олж чадсангүй. Тэр уурандаа "Би та нарт дургүй хүрчихлээ. Би гэр рүүгээ явлаа" гэж хашгирав.

Хүүхдүүд мөр мөрөн дээрээ гараа тавин тойрон зогсоод найгаж байх хооронд асуух: **Хэн нэгэн та нарт "Чи бол миний найз" гэж хэлж байсан уу? Энэ юу гэсэн утгатай вэ? Тиймээ, чи бол сайн найз гэсэн үг. Бүгдээрээ найзын тухай дуу дуулцгаая.** "Найз" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана*, № 256) гэдэг дууг дуулж эхлээрэй. Эсвэл дараах шүлгийг дууны аянд тохируулан дуулаарай.

**Сайн найзууд**

**Би чамд хайртай.  
Чи надад хайртай.  
Бид сайн найзууд, та хараач.  
Сайн найзууд бие биедээ тусалдаг.  
Энэ бол хайр юм.**

**Бататгах нь**

Хүүхдүүдэд хариулах хугацаа өгөөрэй: **Найзууд нэгнийхээ төлөө юу хийдэг вэ?** (залбирах, юмаа хуваалцах, хамтдаа хөгжилдөх, хамтдаа уйлах, хамтдаа тоглох гэх зэрэг). **Энэ долоо хоногт та нар найзтайгаа хэрхэн хандах вэ? Та нар тэрэнд хайртай гэдгээ харуулахад тэд яах бол? Өнөөдрийн бидний гол санаа:**



**Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.**

4

## Хичээлээ Хуваалцах нь

### Сумаа Хуваалцъя

Сумны загварыг ашиглаад (140-р хуудас) хүүхдүүд сумыг хайчилж аваад будах бөгөөд хүүхдүүдэд тэр сумаа сайн найздаа өгөөрэй гэж хэлнэ.

### Багатгах нь

Асуух: **Та нар сумаа хэнтэй хуваалцах вэ? Та нар яагаад тэр хүнийг сонгосон бэ? Та нар тэгвэл**

тэр хүндээ сумаа өгөхдөө Давид болон Ионатан нарын тухай ярьж өгөөрэй. Мөн хайртай гэдгээ ч хэлээрэй. Яагаад гэвэл:



**Үнэнч найзууд бие биенээ хайрладаг.**

**Намайг дагаад хэлээрэй.**

### Хэрэгтэй зүйлс:

- сумны загвар (х. 140)
- хатуу цаас
- өнгийн харандаа
- хайч

### Хичээлийн Хаалт

Хүүхдүүд бие биедээ үнэнч найзууд байж бие биенийгээ хайрлахын төлөө Их Эзэнээс залбиран гуйгаарай.

## ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



### Нөхөрлөл

Хэрэв зохимжтой гэж үзвэл хүүхдүүдийн орохдоо танд хэлсэн, тэдэнд таалагдсан эсвэл таалагдаагүй зүйлүүдийн тухай бусдад нь дуулгаарай. Өнгөрсөн долоо хоногт сурсан мэдсэн зүйлсээ болон цээжилсэн ишлэлээ сэргээн давтах цаг гаргаарай. Төрсөн өдөр, тэмдэглэлт үйл явдал болон амжилт бүтээлийг тэмдэглэхээ мартуузай. Ирсэн зочиддоо онцгойлон талархаарай.

### Санал болгох дуунууд

"Есүсийн найз" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 254)

"Нөхөрлөл" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 255)

"Найзууд" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 256)

"Бие биедээ найрсаг байцгаая" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 260)

"Есүс бол миний сайн найз" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 299)

### Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс түүх ашиглаарай.

### Хандив

Хэлэх: **Бид Шаббат хичээлдээ өргөлөө авчирснаараа сайн найз гэдгээ харуулж чадах юм.**

### Залбирал

Хүүхдүүдийг хоёр хоёроор нь суулгаад гарыг нь бариулж өвдөглүүлэн суулгаад найзынхаа төлөө Есүст талархаарай гэж хэлээрэй.

\*Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.



## Сайн Найзууд

### Унших Зүйл

1 Самуел 18:1-5,  
20:1-42; Эцэг  
Өвгөд ба Зөнчид  
х. 649-655.

### Цээжлэх Ишлэл

"Ионатан  
Давидыг өөрийн  
адил хайрлажээ"  
(1 Самуел 18:3).

### Гол Санаа

Үнэнч найзууд  
бие биенээ  
хайрладаг.

*Чиний сайн найз хэн бэ? Та нар хамтдаа юу хийх дуртай вэ? Ионатан Давид хоёр сайн найзууд байсан бөгөөд бие биедээ ихэд хайртай байжээ.*

Саул хаан Давидыг гэртээ дуудуулан хамт амьдрахыг хүсжээ. "Би чамайг миний төлөө ажиллаж цэрэг эр болоосой гэж хүсэж байна" гэж Саул хаан Давидад хэлэв.

Тэгээд Давид Саул хааны гоёмсог ордонд ирж хааны ууган хүү Ионатантай танилцаж сайн найзууд боллоо.

"Нум сум харвахаар явъя" гэж Ионатан Давидыг дуудахад Давид "Морь унахаар явцгаая" гэдэг байлаа.

Израильчууд ч Давидад улам бүр хайртай болсоор байгааг Саул хаан мэдээд ихэд хилэгнэж түүнийг хороохоор шийдэв.

"Аав тань намайг хөнөөх гэж байна" гэж Давид Ионатанд хэлэхэд тэр итгэж ч чадахгүй "Ийм юм байх ёсгүй" гэлээ.

"Үгүй ээ, энэ үнэн, удахгүй найр эхэлнэ, хаан намайг найранд байна гэж бодож байгаа. Би ах нар дээрээ очлоо. Хоёр өдрийн дараа найр эхлэхэд би ирээд хадны ард нуугдаж байя. Аав тань намайг яагаад найран дээр байхгүй байна вэ гэж асуувал гэр лүүгээ явсан гэж хэлээрэй. Хэрвээ тэр ихэд харамсвал хаан намайг хөнөөх гэж байна гэдгийг чи мэдэх болно" гэж Давид Ионатанд хэлэхэд Ионатан "За яахав, чи хадны ард нуугдаж бай. Хэрвээ манай аав үнэхээр чамайг хорлох гэж байвал би чамд ирж хэлье. Миний төлөвлөгөөг сонс. Би хадны

зүгт нум харваад үйлчлэгч хүүг сумыг авхуулахаар явуулна. Хэрвээ би үйлчлэгч хүүг "цаашаа яваа, сум цаана чинь байна" гэвэл аав маань чамайг хорлох гэж байгаа гэсэн үг. Тэгээд чи амар тайван зугтаж болно" гэжээ.

Найр эхэлж Саул хаан Давидын

суудлыг хоосон байгааг хараад юу ч хэлсэнгүй. Дараагийн өдөр нь Давид ахиад л оройн зоог дээр байхгүй байгааг хараад "Давид хаана байна?" гэж Ионатанаас асуужээ.

"Давид гэр лүүгээ явсан" гэхэд Саул хааны царай улайн "Би чамайг Давид хаан болоосой гэж хүсэж байгааг чинь мэдэхгүй гэж бодоо

юу? Давидыг авчир. Би түүнийг хөнөөх болно" гэжээ.

Аав нь үнэхээр Давидыг хөнөөхийг хүсэж байгааг Ионатан мэдээд дараагийн өглөө нь хадны зүгт нум харван үйлчлэгч хүүг явуулж "Цаашаа гүйгээрэй, сум цаана чинь байна" гэж чанга хэлжээ.

Үйлчлэгч хүүг ирэхэд Ионатан түүнийг хот руу буцаагаад Давидтай салах ёс хийв. "Бид бие биетэйгээ хэсэг хугацаанд уулзаж чадахгүй байх. Гэвч бид үргэлж найзууд байх болно" гэж Ионатан хэллээ. Давид "Тийм ээ, бид үргэлж сайн найзууд байх болно" гэж Давид хэлжээ. Тэд үүрд сайн найзууд байсан юм.



# Дасгал Ажил



## Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

- Ионатан** .....Өөрийгөө заах.  
**Давидыг** .....Бусдыг заах.  
**өөрийн адил** .....Өөрийгөө заах.  
**хайрлажээ** .....Гараа цээжин дээрээ зөрүүлээд тавих.  
**1 Самуел 18:3** .....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## Ням

1 Самуел 18:1-5; 20:1-42-г уншаад "Ионатан Давидад найз гэдгээ харуулахын тулд юу хийсэн бэ? Ионатан Давидад хэрхэн тусалсан бэ? Тэд яагаад гунигтай байсан бэ?" гэж асуу.

Хүүхэд тань өөрийн сайн найзынхаа зургийг зурахад нь туслаарай.

## Даваа

1 Самуел 18:1-3-г уншаад хүүхдэдээ утгыг нь тайлбарлаж өгөөрэй. Мөн гэр бүлийн нэг гишүүн хүүхдээ тэврээд хайртай гэдгээ хэлэх бас сонсох хэрэгтэй.

Шаббат хичээл дээр хийсэн сумаа сайн найздаа өгч түүнд Давид болон Ионатан хоёрын тухай ярихад нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл хатуу цаасан дээр сум зурж будаад хайчлахад нь туслаарай.)



## Мягмар

- 1 Самуел 18:4-г хамтдаа уншаад Нийтэд

тустай үйлчлэлд өгч болох хуучин хувцас олж хамтдаа аваачиж тарааж өгөөрэй.

## Лхагва

Хүүхдээрээ бүх найзуудыг нь нэрлүүлж тоолуулан "Чамд хамгийн сайн нэг найз байгаа юу? Чи тэр хүнд яагаад тийм хайртай вэ?" гэж асуу. Есүс тэдэнтэй сайн найз болохыг хүсэж байгааг нь мөн хүүхдэдээ сануулаарай.



## Пүрэв

Хүүхдээсээ сайн найзыг нь асуугаад найзынхаа төлөө юу хийхийг хүсэж байгааг нь мэдэж аваарай. Эсвэл хүүхдийнхээ сайн найзыг оройн хоолонд уриад хамтдаа Баасан гарагт оройн залбирал хийж болно.

Сайн найз өгснийх нь төлөө Есүст талархахыг хүүхдээсээ хүсээд хүүхдээ сайн найз байхын төлөө Их Эзэнд хандан залбируулаарай.

## Баасан

Гэр бүлийн залбирлын үеэр, Давид болон Ионатан нарын түүхийг бүгдээрээ жүжигчилэн тоглоод мөчир болон саваа мод ашиглан нум сум хийхэд нь хүүхдэдээ туслаарай.

"Найз нартаа хайртай гэдгээ чи яаж харуулж чадах вэ?" гэж хүүхдээсээ асуугаад залбирлынхаа өмнө нөхөрлөлийн тухай дуу дуулж хүн бүрийн найз нарын төлөө Есүст талархаарай.